



Батлав:Л.Одонтуяа.....СНГ-ын дарга Л.Одонтуяа

**БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАЖ БҮЙ ОЮУТНУУДАД
ЗОРИУЛСАН АНГЛИ ХЭЛНИЙ ТҮВШИН ТӨГТООХ
ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар МУИС-ийн сургалтын журмыг шинэчлэн баталсан. Тус журмын 4.12.2.3-т “Бакалаврын хөтөлбөрийн төгсөгч нь англи хэлний ахисан дунд (upper intermediate) түвшний мэдлэг эзэмшсэн байх бөгөөд TOEFL, IELTS-ийн харгалзах түвшний оноонос дээш оноотой эсвэл МУИС-ийн гадаад хэлний сургалтын төвийн шалгалтаар амжилттай дүгнэгдсэн бол шаардлага хангасан гэж үзнэ. Ахисан дундаас дээш түвшний англи хэлний хичээлийг МУИС дээр судалсан бол англи хэлний шалгалт өгөх шаардлагагүй, болзол хангасан гэж үзнэ” гэж заасан. Иймд 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрөөр сурч буй оюутнуудад зориулан англи хэлний түвшин тогтоох шалгалтыг тогтсон улирал бүрт зохион байгуулна.

Зорилго:

МУИС-ийн бакалаврын хөтөлбөрийн төгсөгчийг англи хэлний ахисан дунд түвшний мэдлэгтэй ур чадвартай дээд боловсролтой иргэн болгох зорилгын хэрэгжсилтийг хангаж суралцагчдын түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулах.

Ач холбогдол:

Бакалаврын хөтөлбөрт суралцагчийг суралцах хугацаандaa улирал бур тогтсон хугацаанд шалгалтыг өгч төгсөх шаардлагaa биелүүлэх боломжсоор хангах.

Хамрах хүрээ:

2014-2015 оны хичээлийн жилээс хойши элссэн бакалаврын өдрийн хөтөлбөрийн оюутнууд.

Зохион байгуулах нэгж:

1. Шалгалтыг Сургалтын нэгдсэн газрын Бүртгэлийн алба (БА), Гадаад хэл сургалтын төв (ГХСТ), Мэдээллийн технологийн газар (МТГ), Оюутны хөгжил, үйлчилгээний газар (ОХҮГ) хамтран зохион байгуулах;
2. Гадаад хэлний сургалтын төв англи хэлний ахисан дунд (upper intermediate) түвшний суралцагчийн мэдэх ёстой мэдлэг, ур чадварыг сорьсон тестийн санг боловсруулж СНГ-аар баталгаажуулна. Тестийн сан нь англи хэлний унших дадал 30 хувь, бичих дадал 40 хувь, сонсох дадал 30 хувь байхаар шалгуулагч бүрт өөр өөр хувилбар сонгогдохоор тооцоолж асуулга боловсруулж, баяжуулан МТГ-т хандан тестийг сургалтын мэдээллийн системд байршуулах, шалгалтын үеэр ажиллах шалгагч багшийн ажиллах хуваарь, зааврыг боловсруулах, оюутны бичиг баримтыг үндэслэн шалгалт авах анги

- танхимд шалган оруулж суралцагчийг хувийн эрхээрээ нэвтрэн орж байгаа эсэхэд хяналт тавих;
3. Мэдээллийн технологийн газар батлагдсан тестийн санд үндэслэн шалгалтыг авах програм боловсруулан сургалтын мэдээллийн системтэй холбон суралцагч шалгалтыг цахим хэлбэрээр өгөх боломж, шалгалтанд тэнцсэн эсэхийг тодорхойлсон тэмдэглэгээг системд бий болгох, бүртгэлтэй компьютераас хандах тохиргоог хийх;
 4. Оюутны хөгжил, үйлчилгээний газар түвшин тогтоо шалгалтын тухай шинээр элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалт болон зөвлөх багштай хамтран суралцагчдыг мэдээллээр хангахад хамтран ажиллах;
 5. Бүртгэлийн алба шалгалтыг зохион байгуулах, суралцагчдад зөвлөгөө мэдээлэл өгөх, анги танхимын хуваарь гаргаж, шалгалтанд хяналт тавин ажиллана.

Зохион байгуулах хугацаа, анги танхим:

1. Шалгалтыг улирал бүрийн хичээлийн 10-11 дэх долоо хоногт ажлын 5 өдөр 07:40- 19:10 цагийн хооронд авна.
2. Гадаад хэлний сургалтын төвийн техникийн шаардлагыг хангасан сургалтын мэдээллийн системд холбогдох боломжтой анги танхимд зохион байгуулна.

Шалгалт зохион байгуулах тухай мэдээлэх:

1. Түвшин тогтоо шалгалт авах тухай улирал бүрийн 8-9 дүгээр долоо хоногт Сургалтын мэдээллийн систем, МУИС-ийн веб хуудас болон бүрэлдэхүүн сургуулийн мэдээллийн самбарт байршуулна.
2. Шалгалтын хуваарийг оюутан 9-10 долоо хоногт сургалтын мэдээллийн системээр сонгоно.
3. Анги танхимын байршил хаягийг тухайн үед нь мэдээллэнэ.

Шалгалтын үр дүнг оюутанд мэдэгдэх:

- Оюутан түвшин тогтоо шалгалтыг өгч тэнцсэн бол ахисан дунд түвшний англи хэлний болзлыг хангасан гэж үзэн сургалтын мэдээллийн системд ТЭНЦСЭН гэсэн тэмдэглэгээг оруулна.
- Тэнцээгүй бол дараагийн улиралд зохион байгуулах шалгалтад орох боломжтой.

Дүн шинжилгээ хийх:

Улирал бүр зохион байгуулж буй түвшин тогтоо шалгалтын үр дунд ГХСТ, СНГ, МТГ хамтран дун шинжилгээ хийж цаашид сайжруулах арга хэмжээ авна.

Тайлбар:

- *Англи хэлний ахисан дунд (upper intermediate) шатны хичээлийг судалж амжилттай дүгнэгдсэн бол,*
- *TOEFL, IELTS-ийн харгалзах түвшний онооноос дээши оноотой бол,*
- *Англи хэлний ахисан дунд шатны хичээлийг судалж байгаа бол тухайн улиралд зохион байгуулагдах түвшин тогтоо шалгалтанд хамрагдахгүй.*